131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,462,202.00	1,620,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, сурлагын хоцрогдлыг арилгах” зорилго дэвшүүлэн ажилласан байна..

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед малчин айлын хүүхдүүдэд сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг бүрдүүлэх, цахим хичээлээр хичээл заах боломж бүрдүүлэх, харилцах дэвтэр болон бие даан ажиллах даалгаврын сантай болох
- Багш бүр хоцрогдлыг арилгах талаар тусгай төлөвлөгөө гаргаж, суралцагчдын сургалтын чанарт ахиц гаргах
- Чадвартай багшийг сонгон шалгаруулах шалгаруулалтыг ил тод шударгаар зохион байгуулах зорилго, зорилтыг мөрдлөг болгох
- Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын явц, үр дүнд тогтмол шинжилгээ хийж хоцрогдлыг арилгах сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлж ажиллах
- Дунд, ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээг сургууль бүр төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас сургуулийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 2.4 сая төгрөгийн акт тогтоож, төлбөрийн барагдуулсан. Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сургуулийн захирлын 2019 оны 103 тоот тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг батлан мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.5 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		84,384.7	84,384.65
Авлага	1,987.8		(1,987.98)

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	60,262.5	58,357.0	(1,905.51)
Үндсэн хөрөнгө	1,605,363.5	1,516,392.3	(88,971.16)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,667,614.0</b>	<b>1,659,134.0</b>	<b>(8,480.0)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,667,614.0	1,659,134.0	(8,480.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,667,614.0</b>	<b>1,659,134.0</b>	<b>(8,480.0)</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна..

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 84.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нормативт зардал, бараа үйлчилгээний зардал, үдийн цайны зардлуудын хэмнэлт байна. Дээрх зардлуудаас хоол, үдийн цайны зардлын хэмнэлт 15.9 сая төгрөг байна.

Оны эхний авлагаа барагдуулсан Урьдчилж гарсан зардал данс оны эхэн, эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын данс 1.9 сая төгрөгөөр буурсан нь хоол хүнс болон түлш шатах тослох материалын үлдэгдэл буурсан, аж ахуйн бичиг хэргийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой, аж ахуйн материалын үлдэгдэл 18.0 сая төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд 19.5 сая төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 31.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 13.0 сая, үнэ төлбөргүй 27.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 7.1 сая төгрөгийн хөрөнгө акталж, 1.9 сая төгрөгийн 0.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийн шилжүүлж, үндсэн хөрөнгөнд тайлант онд 128.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Сумын ИТХ-ын хуралдааны 19 дугаар тогтоолоор элэгдлээ бүрэн нөхсөн 7.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан боловч сургуулийн захирлын тушаалаар устгалын комисс байгуулж, акталж устгаагүй байна.

Сургуулийн захирлын 2022 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хагас дутуу хөтөлсөн, тооллогын дүнг хэлэлцэж тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл болох 481.6 сая төгрөгийн хөрөнгийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Өр төлбөр дансыг оны эцэст үлдэгдэлгүй тайлагнасан боловч 3.5 сая төгрөгийн татварын өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Тайлант онд -8.5 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс -8.5 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт БӨА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,180.2 сая, орон нутгийн төсвөөс 194.0 сая, нийт зарлагыг 3,374.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 239.6 сая төгрөгөөр бууруулж 3,134.6 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,837.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 294.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос нийтдээ 3,134.7 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,837.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 294.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 3.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулж оны эцэст 84.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,050.3 сая төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь хоол, үдийн цай, бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80112-Нийтлэг үйлчилгээ	293,978.50	293,978.50	-	100.00
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	7,378.80	7,378.80	-	100.00
3	80312-Сургалт семинар	3,689.40	3,689.40	-	100.00
4	80823-Эрүүл мэндийн арга хэмжээ	8,485.60	8,485.60	-	100.00
5	81801-Үдийн цай	201,994.80	193,371.00	(8,623.80)	95.73
6	81806-Дотуур байрны үйлчилгээ	263,836.90	256,516.00	(7,320.90)	97.23
7	81816-Хүүхдэд ээлтэй орчин	80,920.00	12,480.00	(68,440.00)	15.42
8	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	16,602.30	16,602.30	-	100.00
9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,028,705.10	2,028,705.10	-	100.00
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	225,998.50	225,998.50	-	100.00
11	81848-Сурах бичгийн түрээс	3,065.00	3,065.00	-	100.00
	<b>Дүн</b>	<b>3,134,654.90</b>	<b>3,050,270.20</b>	<b>(84,384.70)</b>	<b>97.31</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь тайлант онд 1.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилт авч, зориулалтын зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

БӨА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,566.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 39.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: нормативт зардлыг 7.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 68.5 сая, үдийн хоолны зардлыг 8.6 сая, нийт 84.4 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 398.4 сая төгрөгийн зарлагын 17 мөнгөн гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 24.2 сая төгрөгийн 4 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 50% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар 0.7 сая төгрөгийн акт тогтоосныг барагдуулсан боловч төсвөөс төлсөн, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт:4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	733.5			0%
Албан шаардлага	1	5,743.6	1	5,743.6	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5,743.6</b>	<b>1</b>	<b>5743.6</b>	<b>50%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй, эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

Дараагийн аудитаар орон тооны гүйцэтгэл, хоол, үдийн цайны төсвийн зарцуулалт, бараа материалын тайлан гаргалт, тооллого, тооцоо хийсэн байдал, нягтлан бодох бүртгэлийн БӨА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хөтлөлт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналтын хэрэгжилтийг анхаарах шаардлагатай.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 951.0 сая төгрөгийн зөрчил илэрч 6.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 939.7 сая төгрөгийн албан шаардлага, 5.1 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө. Үүнээс сургуулийн захирал, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Сургуулийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/9 дүгээр хамтарсан тушаалыг баримтлаагүй, сумын Засаг даргын захирамж гаргуулаагүй 2.3 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хууль бус авсан.

2. Нягтлан бодогч нь сургуулийн захирлын тушаалаар ур чадварын нэмэгдлийг 20 хувиар олгохоор тогтоосныг 25 хувиар бодож 0.5 сая төгрөгийн нэмэгдлийг илүү авсан.

3. Ажиллагсдын цалингаас нийтдээ 157.8 сая төгрөгийн татварыг суутган авч 152.3 төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 3.5 сая төгрөгийн татварыг төсөв төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан.

### **5.2 Албан шаардлага:**

Аудитаар дараах зөрчлүүдэд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж нярвын 1 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 8.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан.

2. Хоолны зардлын төсвөөс оны эцэст цалингийн ашигт 14.9 сая, НДШ-д 1.7 сая, мэдээлэл технологийн зардлаас 3.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 4.0 сая төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал нийтдээ 23.8 сая төгрөгийг холбогдох зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан.

3. Нярвын аж ахуй, бичиг хэрэг, урсгал засварын материалын зарцуулалтын тайлан гаргаагүй, шаардахаар хуудсаар зарлагдсан, түрээсийн номын орлого 3.1 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд хамруулан захирлын 2022 оны Б/82 тушаалаар аймгийн "Сумдын бүсийн иргэдийн спортын наадам"-ын удирдамжийг үндэслэн ирсэн зочдыг хүлээн авах арга хэмжээнд зарцуулсан боловч хувь хүний дансанд нэхэмжлэл, зарлагын падаангүй шилжүүлэн, зарцуулалтын тайланг гаргаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.

4. Сургуулийн 2 няравт нь жилийн турш 434 цаг буюу 2.3 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгож, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар сургуулийн захиралд тавьсан 0.7 сая төгрөгийн төлбөрийг сургуулийн төсвөөс төлж, төсвөөс үргүй зардал гаргасан.

5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 398.4 сая төгрөгийн зарлагын 17 мөнгөн гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шийдвэр ийн 24.2 сая төгрөгийн зарцуулалт гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 50% байна.

*Аудитаар дараах зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*

1. Сургуулийн захирлын 2022 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хагас дутуу хөтөлсөн, тооллогын дүнг хэлэлцэж тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл болох 481.6 сая төгрөгийн хөрөнгийг тулган баталгаажуулах боломжгүй.

### 6.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

##### 1.1.Илрүүлэлт:

Сургуулийн балансад элэгдлээ бүрэн нөхсөн, биетээр байхгүй 5.1 сая төгрөгийн ачааны машиныг бүртгэж, актлах шийдвэр гаргуулаагүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Хуримтлагдсан элэгдлээр анхны өртгөө бүрэн нөхсөн 5.1 сая төгрөгийн ачааны машиныг актлах шийдвэр гаргуулж, данснаас хасах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналты

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

									албан шаардлага		н байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингаас суутгасан 3,487.4 мянган төгрөгийн татварыг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй	1	3487.4	1	3487.4								
Сургуулийн захирал журам зөрчиж ур чадварын нэмэгдэл авсан, нягтлан бодогч ур чадварын нэмэгдлийг тогтоосон хэмжээнээс илүү авсан.	1	2756.7	1	2756.7								
Хоолны зардлын төсвөөс цалингийн ашиг, НДШ, мэдээлэл технологийн зардлаас үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, аж ахуйн материал холбогдох зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан.	1	23760.3			1	23760.3						
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй	2	481587.7							2	481,587.7		
Элэгдлээ бүрэн нөхсөн, биетээр байхгүй ачааны машиныг актлах шийдвэр гаргуулаагүй байна.	1	5065.2					1	5065.2				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>516,657.3</b>	<b>2</b>	<b>6,244.1</b>	<b>1</b>	<b>23760.3</b>	<b>1</b>	<b>23760.3</b>	<b>2</b>	<b>481,587.7</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй	1	423,007.7			1	423,007.7		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>423,007.7</b>			<b>1</b>	<b>423,007.7</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж 1 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс үргүй зардал гаргасан. Няравт илүү цагийн хөлс олгож, өмнөх оны аудитаар тавьсан актыг төсвөөс төлсөн	1	11,377.2			1	11,377.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>11,377.2</b>			<b>1</b>	<b>11,377.2</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>434,384.9</b>			<b>2</b>	<b>434,384.9</b>		